



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/185

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 70 дугаар зөвлөмжүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх ГААЭМГ/202312003 дугаартай "Хөхморьт сумын Эрүүл мэндийн төвд" автомашин худалдан авах тендер шалгаруулалтад шалгарсан "Оттомир" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2.Ажил гүйцэтгэх хугацаа, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т үүрэг болгосугай.

3.Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

